

Оюу толгойг хэн сайн мэдэх вэ?

Би энэхүү эсээндээ оюу толгойн тухай хүн бүрийн өдөр болгон ярьдаг, сонсдог тоо баримт цуу ярианы талаар бичихгүй. Харин өөрийн үзэл бодлоороо оюу толгой хэмээх байгууллагын талаар дурьдахыг хүслээ. Эрсдэл ашиг хоёр эерэг хамааралтай гэдэг мэргэн үг байдаг. Алдаа гарахгүй бас эрсдэл хүлээхгүй байгаа бол тэнд ололт амжилт, арвин туршлага хуримтлагдахгүй. Өөрөөр хэлбэл одоо хийгдсэн байгаа болон ирээдүйд хийгдэх үйл ажиллагааг алдаатай, учир дутагдалтай гэсэн шүүмжлэл байгаа хэдий ч түүний хажуугаар оносон, хожсон зүйл нилээдгүй байгаа. Аливаа зүйлийн болохгүй болон бүтэхгүй талаар нь яриад эсвэл тэр өнцөгөөс нь хараад байвал тухайн зүйл амжилтанд хүрнэ гэвэл үлгэр болж хувирна. Ингэхлээр яах ёстой вэ? гэдэг асуулт зайлшгүй тулгарна. Тухайн зүйлийн болж байгаа болон эерэг нөлөөлөл үзүүлж байгаа хэсэгт анхаарлаа хандуулж түүнийг олон нийтэд нийгэмд таниулж чадвал тэр өөрөө эерэг нөлөөлөл өөрчлөлт болж чадна.

Оюу толгойг манай нутагт байдаг гэдгээр нь би сайн мэднэ. Энэ том бүтээн байгуулалтанд өөрийн биеэр очиж үзээгүй ч өдийг хүртэл үр шимийг хүртсээр байгаа нэгэн. Тухайн улс орны хөдөлгөгч хүч ирээдүйн хөгжлийн хөтөч нь залуучууд байдаг. Тэр дундаа зөв ухамсар хүмүүжилтэй, өндөр боловсрол мэдлэгтэй, чадварлаг залуучууд байдаг. Нийгмийн энэ хамгийн чухал хэсэгт миний мэдэх оюу толгой хөрөнгө оруулалт хийдэг. Чадварлаг оюутнуудын сургалтын төлбөрийг нь төлж байрны мөнгийг нь өгдөг. Өөрөөр хэлбэл сургалтын тэтгэлэгт хөтөлбөр зарлаж маш олон чадварлаг оюутнуудыг өөрийн хүсэл мөрөөдлөө биелүүлэхэд нь дэмжлэг туслалцаа өгдөг.

Би 4 дүүтэй айлын том хүү. Манай гэр бүлд ээж маань л ажил хийж биднийг тэжээдэг. Их сургуульд төлбөр төлөөд орон нутгийн хүүхэд сурна гэдэг манайх шиг айлын хувьд бол мөрөөдөл төдий л зүйл. Гэтэл энэ мөрөөдлийг минь биелүүлж өгсөн байгууллага бол “Оюу толгой” компани. Би энэ байгууллагын сургалтын тэтгэлэгт хөтөлбөрт 3 жил хамрагдаж байна. Энэ тэтгэлэгийг би нүдээ олсон тэтгэлэг байсан гэж бодож байна. Өнөөдөр би Их сургуулийнхаа хамгийн шилдэг оюутан болж чадсан бас үндэсний мэтгэлцээний тэмцээний аварга болж чадсан.

Хүн бүр оюу толгойн талаар өөр өөрийнхөө л мэддэг зүйлээ бичж байгаа байх. Учир нь хүн бүхэнд өөр өөрөөр танигдсан бас нөлөөлсөн болохоор тэр. Энэ бол миний л мэдэх оюу толгой. Магадгүй зарим нь оюу толгойн гэрээний асуудлаар, ажлын байрны талаар, хөрөнгө оруулалтын талаар гэх мэтчилэн олон том асуудлуудын талаар бичиж байгаа байх. Гэхдээ хүн өөрийнхөө мэддэг зүйлийнхээ талаар л сайн ярьж бас бичиж чаддаг. Тийм болохоор оюутан надад танигдсан оюутолгой бол миний мөрөөдлийг биелүүлэгч байсан юм. Цаашид ч гэсэн олон олон шилдэг залуусыг монголын ирээдүйн хөгжлийн төлөө бэлтгэн гаргахад өөрийн үнэтэй хувь нэмрээ оруулна гэдэгтэй итгэлтэй байна.

**Монгол Улсын Их Сургуулийн Худалдааны Сургуулийн
Бизнесийн эрх зүйн анги 4-р курсын оюутан
Т.БУЯНДЭЛГЭР**